

”ДУЛААНЫ ДӨРӨВДҮГЭЭР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК

Огноо: 2020-05-15

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР ШАЛГАРУУЛАХ

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалт / *Үйлдвэрийн уурын шугам засвар*  
гэрээний нэр:

Тендер шалгаруулалт /  
гэрээний дугаар:ЗА-  
2020/22

Нэг. **ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

ДЦС-IV ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **АҮ-2020/22 Үйлдвэрийн уурын шугам засварын ажил” гүйцэтгэх** үнийн санал ирүүлэхийг урьж байна. Тендер нь түүнийг нээсэн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээс үнэ төлбөргүй авч болно.

Үнийн саналыг **2020 оны 05-р сарын 21-ны өдрийн 10.00 цагаас** өмнө Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр илгээх бөгөөд 1 хувийг цаасаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 05-р сарын 21-ны өдрийн 10.30-т** цахим системээр нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**“ДЦС-4” ТӨХК ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС**  
**Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж**  
**Захиргааны байр 3-р давхар 311,312 тоот өрөө**  
**Утас:70181309, 7017-1357**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ү.ТӨМӨРХУЯГ

ХААХ-ИЙН ДАРГА

О.ГАНТӨМӨР

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**

4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.

4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.

4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн

дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТООЗ-ны холбогдох заалт</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТООЗ 1.1</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан / аудитын дүгнэлтийн хамт/;</li> <li>2. Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбарын хамт /</li> <li>3. Бусад нэмэлт шаардлага</li> </ol> <ul style="list-style-type: none"> <li>- Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. <i>/0.7-80.0 кгх/см2-аас даралттай савны засвар, угсаралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ шугам засвар угсралт/</i></li> <li>- Гэрээг гүйцэтгэх удирдах ажилтан, ХАБ-ын инженерийн мэдээлэл</li> <li>- Цахилгаан гагнуурчины тоо 1а категортой 2-оос багагүй</li> <li>- Огтлогчийн тоо 1-ээс багагүй байх</li> <li>- Оосорлогч дохиочин 2-оос багагүй</li> </ul> <p>Дараах үндсэн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ажил гүйцэтгэх хугацаанд Өргөх зөөх, машин механизмтай байх (өөрийн, түрээслэх, хөлслөн авах гэх мэт )</p> <ol style="list-style-type: none"> <li>2. Аргон гагнуурын хэрэгсэлтэй байх</li> <li>3. Хийн огтлох хэрэгсэл 1-ээс доошгүй байх</li> </ol>
<b>ТООЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:  Огноо: <b>2020 оны 05 дугаар сарын 21-ны өдөр</b>  Цаг: <b>10 цаг 00 минут</b>  Тендер хүлээн авах этгээд: <b>В.Лхагвадорж</b>  Байгууллагын хаяг: <b>Баянгол дүүрэг 20-р хороо “ДЦС-4” ТӨХК-ний байр</b>  Давхар болон өрөөний дугаар: <b>Захиргааны 1-р байр 3-р давхар 310 тоот өрөө</b>  Аймаг, хот: <b>Улаанбаатар хот Баянгол дүүрэг</b>  Шуудангийн дугаар: <b>36</b>  Улс: <b>“Монгол Улс” Факс 70181309 утас 70181309</b></p>
<b>ТООЗ 2.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:  Байшин, гудамжны нэр: <b>Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж “ДЦС-4” ТӨХК-ий байр</b>  Давхар болон өрөөний дугаар: <b>Захиргааны 1-р байр 3-р давхар 310 тоот өрөө</b>  Аймаг, хот: <b>Улаанбаатар хот Баянгол дүүрэг</b>  Шуудангийн дугаар: <b>36</b></p>
<b>ТООЗ 6.2</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:  Турбоагрегат №6-ын Өндөр даралтын халаагчийн их засварын ажил</p>

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ҮЙЛДВЭРИЙН УУРЫН ШУГАМ СОЛИХ ИХ ЗАСВАРЫН АЖИЛ

д/д	Хийгдэх ажил	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
1	Үйлдвэрийн уурын "А"шугам 105-р цэгээс 117-р цэг хүртэл ф426х10 шугамын дулаалга буулгах /112м/	23	м3	
2	Үйлдвэрийн уурын"А"шугам 105-р цэгээс 117-р цэг хүртэл ф426х10 шугамын демонтаж хийх /112м/	135	м	
3	117-р цэгээс Монсүү ХХК-ны худаг хүртэл газар доорхи ф426х10 шугамыг ухаж ил гаргах /18м/	90	м3	
4	117-р цэгээс Монсүү ХХК-ны худаг хүртэл газар доорхи ф426х10 шугамын дулаалга буулгах /18м/	2.26	м3	
5	Булан солих ф426х10	8	Ширхэг	
6	Үйлдвэрийн уурын шугамын 105-р цэгээс Монсүү ХХК-н худаг хүртэлх ф426х10 шинэ шугамыг үл хөдлөх,гулсах тулгуур болон хаалт арматурын хамт угсрах /135м/	0.135	км	
7	Гагнуурын оёдлыг металл судлалын лаборатороор үзлэг хийлгэх	20	Ширхэг	
8	ф426х10 шугамыг шилэн хөвөнгөөр /шахмал/дулаалах /135м/	180.6	м2	
9	ф426х10 шугамыг төмөрлөх	278	м2	
10	Шинээр сольсон шугамын газар доогуурх хэсгийн тагийг тавьж шороогоор булаах	90	м3	
11	Хавтан угсрах	5	Ширхэг	
12	Уураар үлээлгэн цэвэрлэж нягтын шахалт хийх	1	Удаа	
13	Үйлдвэрийн уурын "Б"шугам 105-р цэгээс 117-р цэг хүртэл ф426х10 шугамын дулаалга буулгах /112м/	23	м3	
14	Үйлдвэрийн уурын"Б"шугам 105-р цэгээс 117-р цэг хүртэл ф426х10 шугамын демонтаж хийх /112м/	135	м	
15	117-р цэгээс Монсүү ХХК-ны худаг хүртэл газар доорхи ф426х10 шугамыг ухаж ил гаргах /18м/	90	м3	
16	117-р цэгээс Монсүү ХХК-ны худаг хүртэл газар доорхи ф426х10 шугамын дулаалга буулгах /18м/	2.26	м3	
17	Чиг өөрчлөгч угсрах	8	Ширхэг	
18	Үйлдвэрийн уурын шугамын 105-р цэгээс Монсүү ХХК-н худаг хүртэлх ф426х10 шинэ шугамыг үл хөдлөх,гулсах тулгуур болон хаалт арматурын хамт угсрах /135м/	0.135	км	
19	Гагнуурын оёдлыг металл судлалын лаборатороор үзлэг хийлгэх	20	Ширхэг	

20	ф426х10 шугамыг шилэн хөвөнгөөр /шахмал/дулаалах /135м/	180.6	м2	
21	ф426х10 шугамыг төмөрлөх	278	м2	
22	Шинээр сольсон шугамын газар доогуурх хэсгийн тагийг тавьж шороогоор булах	90	м3	
23	Хавтан угсрах	5	Ширхэг	
24	Уураар үлээлгэн цэвэрлэж нягтын шахалт хийх	1	Удаа	

**“Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжуудыг засварлах хөдөлмөрийн нэгтгэсэн норм ЭХН-8-81-02-2007” номыг үндэслэн төсөв зохионо.**

Төсөвт ажлын тарифт цалинг “ДЦС-4” ТӨХК-ий гүйцэтгэх захирлын 2018 оны 10-р сарын 10-ны өдрийн А/235 тоот тушаалын дагуу тооцно.

“ДЦС-4” ТӨХК-ийн  
Гүйцэтгэх захирлын 2018 оны 10  
дугаар сарын 10-ний өдрийн А/235  
дугаар тушаалын хавсралт

Эрчим хүчний тоноглол, барилга сантехникийн засварын төсөвт ажлын жишиг тарифт цалин

Төгрөг

1.0	2,285.71	2.0	2,537.14	3.0	2,857.14	4.0	3,291.43	5.0	3,794.29	6.0	4,388.57
1.1	2,310.86	2.1	2,569.14	3.1	2,900.57	4.1	3,341.71	5.1	3,853.71		
1.2	2,336.00	2.2	2,601.14	3.2	2,944.00	4.2	3,392.00	5.2	3,913.14		
1.3	2,361.14	2.3	2,633.14	3.3	2,987.43	4.3	3,442.29	5.3	3,972.57		
1.4	2,386.29	2.4	2,665.14	3.4	3,030.86	4.4	3,492.57	5.4	4,032.00		
1.5	2,411.43	2.5	2,697.14	3.5	3,074.29	4.5	3,542.86	5.5	4,091.43		
1.6	2,436.57	2.6	2,729.14	3.6	3,117.71	4.6	3,593.14	5.6	4,150.86		
1.7	2,461.71	2.7	2,761.14	3.7	3,161.14	4.7	3,643.43	5.7	4,210.29		
1.8	2,486.86	2.8	2,793.14	3.8	3,204.57	4.8	3,693.71	5.8	4,269.71		
1.9	2,512.00	2.9	2,825.14	3.9	3,248.00	4.9	3,744.00	5.9	4,329.14		

251.43                      320.00                      434.29                      502.86                      594.29  
25.14                      32.00                      43.43                      50.29                      59.43



## Тав. ЗУРАГ

### Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

### Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Техникийн тодорхойлолтод заагдсан ажлын эзлэхүүний дагуу гаргасан график, түүнд үндэслэсэн үе шатны ажлын хуваарь ирүүлнэ.

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

### Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br><br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |

5. **Зааварчилгаа** 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
6. **Маргааныг шийдвэрлэх** 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## **Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**

7. **Ажлын хөтөлбөр** 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
- 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
8. **Зөрчил, гологдол илрүүлэх** 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
9. **Зөрчил, гологдол арилгах** 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа<sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
10. **Зөрчил, гологдол арилгахгүй байх** 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

---

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 11.3.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежер тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг
- 14.2. мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтгэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш

---

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.

**16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.

Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.

Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

**17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага** 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

**18. Гэрээг цуцлах** 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**19. Гэрээг  
цуцалсан үед  
хийх төлбөр**

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээс  
чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

### Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>3</sup>

<b>ГЕН 1.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: АҮ-2020/22
<b>ГЕН 1.2</b>	Ажил нь : <i>Турбоагрегат№6-ын Өндөр даралтын халаагчийн их засварын ажил</i> Ажлын талбай нь: Турбин цехэд байрлана.
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь <i>ЗА-ны дарга Ц.Амарбаясгалан</i>
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр: <b>2020-06-02</b>  Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: <b>2020-07-30</b>
<b>ГЕН 4.2</b>	Гүйцэтгэгчийн ажиллагсад нь өөрийн компаний эмблем, лого, эсвэл таних тэмдэг бүхий Захиалагчийн ажиллагсаас ялгарах ажлын хувцастай байх ба мэргэжлийн үнэмлэхээ биедээ авч явна.
<b>ГЕН 4.2</b>	Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхдээ Цахилгаан станц, дулааны шугам сүлжээний дулаан механикийн тоноглолын ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны дүрэм болон Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм/ ААД/, Цахилгаан станц, шугам сүлжээний техник ашиглалтын дүрэм/ТАД/ ГАУСД, Уурын болон усан халаалтын зуухыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм, Даралтат савыг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм, Компаний дотоод журам болон Эрчим хүчний салбарт одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дүрэм журам заавруудыг ягштал мөрдөнө.
<b>ГЕН 4.2</b>	Засварын ажлыг гүйцэтгэгч компани нь аливаа ажлыг гүйцэтгэхдээ мэргэжлийн зэрэг, категори, албан тушаал нь тохирох, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагад нийцсэн “нарядын хариуцлагатнууд”-ын нэрсийн жагсаалтыг захиалагчид ирүүлж батлуулах ба тэдгээр хариуцлагатнууд нь засварын ажлыг гүйцэтгэх явцад нарядын системийг чанд мөрдөнө
<b>ГЕН 4.2</b>	Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангуулах, галын аюулаас урдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч ажиллах ба зөрчил гаргасан болон тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд Хяналтын Албаны шаардлагаар ажлыг зогсоох хүртэл арга

<sup>3</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

	хэмжээ авна
<b>ГЕН 4.2</b>	Цахилгааны схем, зөөврийн болон байнгын гэрэлтүүлгийг холбох, таслуулах, шилжүүлэх тохиолдолд Захиалагч талын шуурхай ажиллагааны хүмүүст захиалга өгч, мэргэжлийн хүнээр гүйцэтгүүлэх үүрэгтэй. Мөн станцын суурин өргөх, зөөх механизмаар үйлчлүүлэх, шаардлагатай хийц, бэлдэцийг Механик цехэд урьдчилан захиалга өгч гүйцэтгүүлнэ.
<b>ГЕН 4.2</b>	ХХ, ААД, ТАД, станцын дотоод журам болон ЭХ-ий салбарт мөрдөгдөж байгаа дүрэм журмыг зөрчсөнөөс, түүнчлэн өөрсдийн буруугаас тоног төхөөрөмжийг гэмтээсэн, үйлдвэрлэлийн осол гаргасны улмаас учирсан хохирол, хариуцлагыг гүйцэтгэгч байгууллага бүрэн хариуцах үүрэгтэй
<b>ГЕН 6.1</b>	Талууд гэрээтэй холбоотой асуудлаар гарах Маргаан зөрчилдөөнийг аль болох эвийн журмаар шийдвэрлэхийг хичээнэ. Маргаан зөрчилдөөнийг 30 хоногийн эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй бол дараа шүүхэд шийдвэрлүүлэхээр хандаж болно.
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 7.2</b>	Гүйцэтгэгч нь засвараас гарсан хог хаягдлыг тухай бүр нь зайлуулж байхын зэрэгцээ захиалагчийн төлөөлөгч, техникийн удирдлага болон байцаагч нарын тавьсан шаардлагыг бүрэн биелүүлж хариуг бичгээр буюу амаар цаг тухайд нь мэдэгдэж байх үүргийг хүлээнэ
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа тоноглолыг ажилд залгасанаас хойш <b>90</b> хоног байна.
<b>ГЕН 11.1</b>	Засвар хийгдэх барилга байгууламж, цахилгаан дулаан, цэвэр бохир усан хангамж, инженерийн шугам сүлжээний ажлын засвар хийгдэх хэсгийг тодорхойлсон техникийн нөхцөл, ажлын зураг, төсөв, холбогдох баримт материалыг ажил эхлэхээс 7 хоногийн өмнө гүйцэтгэгчид өгсөн байх үүрэгтэй
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <b>0,3 %</b> байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,3% байна.
<b>ГЕН 17.1</b>	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг/ шахалт туршилтын актыг нэгж тоноглолын засвар дуусах бүр гаргаж өгнө. Тухайн ажлын гүйцэтгэлийн зураг, төсвийн дагуу үнэн зөв гаргаж, далдлагдсан ажил, засварлагдсан узель эд ангиудын хүлээлгэн өгөх акт, тоноглолыг технологийн дагуу туршиж тохируулсан актыг тухайн



	<p>тоноглолын засвар дуусахын өмнө гаргаж өгнө.</p> <p>Гүйцэтгэгч ажил гүйцэтгэсний дараа дараах бичиг баримтыг 4 % бүрдүүлнэ.</p> <p>Үүнд. 1. Ажил гүйцэтгэх гэрээ</p> <p>Анхны батлагдсан төсөв</p> <p>Ажлын гүйцэтгэл</p> <p>Ажлын гүйцэтгэл хүлээлцсэн комиссын акт</p> <p>Гэрээ дүгнэсэн протокол</p> <p>Материалын тайлан</p> <p>Шахалт туршилтын акт</p> <p>Тоноглолын эд ангиудын засварын өмнөх ба дараах фото зураг</p> <p>Засвараас гарсан хог хаягдлыг зөвшөөрөгдсөн хогийн цэгт хаясан баримт</p> <p>. Хуучин сэлбэг материал тушаасан бичиг</p>
	<p>Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ 150 000 ₮ байна.</p>
<b>ГЕН 18.1</b>	<p>Гүйцэтгэгчийн ажиллагсад Компаний хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн, эд зүйлийг эвдсэн, хулгайлсан, архи уусан, хулгай хийсэн болон хулгайн хэрэгт холбогдсон нь тогтоогдсон, хэв журмын зөрчил гаргасан гүйцэтгэгч байгууллагыг ажлын байрнаас зайлуулж гэрээг цуцлах бөгөөд захиалагчийг хохиролгүй болгож, эвдсэн, хулгайлсан эд зүйлийн үнийн дүнг 3 дахин өсгөсөн үнээр торгууль төлнө</p>
<b>ГЕН 19.1</b>	<p>Хяналтын Албаны шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, эсэргүүцсэн тохиолдолд гэрээг цуцлуулах хүртэл арга хэмжээ авна</p>

БАТЛАВ  
“ДЦС-4” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ                    Ү.ТӨМӨРХУЯГ

БАТЛАВ  
..... ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

### **Үйлдвэрийн уурын шугам засварын ажлын гэрээ**

2020 он . . . дугаар сарын . . .-ны өдөр                    №                    Улаанбаатар хот

Нэг талаас “ДЦС-4” ТӨХК-г төлөөлж ЗА-ны дарга **Ц.Амарбаясгалан** /цаашид захиалагч/, нөгөө талаас “.....” ХХК-ын захирал ...../цаашид гүйцэтгэгч гэх / нар хамтад нь /цаашид талууд гэх/ нар нь Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29-р зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

#### **Нэг.Нийтлэг зүйл**

1.1 Энэхүү гэрээний зорилго нь : **Үйлдвэрийн уурын шугам засварын ажил** -г дор дурьдсан хугацаанд гүйцэтгэж захиалагч талд хэвийн ажиллагааг хангаж хүлээлгэж өгөх, Захиалагч нь гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг дүгнэж зохих шаардлагыг хангасан гэж үзвэл энэхүү гэрээгээр тохирсон хэлбэр, хугацаанд ажлын хөлсийг төлөх, засварын ажил эхлэх, гүйцэтгэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

#### **Хоёр. Гэрээний хугацаа**

- 2.1 Ажил гүйцэтгэх хугацааг календарийн /хуанлийн / ажлын өдрийг удирдлага болгоно.
- 2.2 Ажил гүйцэтгэх хугацаа гэрээний 2.3-т заасан үүрэг биелэгдсэнээр эхэлнэ.
- 2.3 Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажсанаар гэрээ хууль зүйн хүчин төгөлдөр болно.
- 2.4 Гэрээт ажлын хугацаа **2020** оны **06**-р сарын **02**-ноос **2020** оны **07**-р сарын **30**-ний өдөр хүртэл байна.Шаардлагатай тохиолдолд горим ажиллагаанаас хамааран ажил гүйцэтгэх хугацааг наряд нээгдсэн өдрөөс тооцож болно.
- 2.5 Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажлын баталгаат хугацаа нь тоноглолыг явуулж ажилд залгаснаас хойш 3 сар байна.
- 2.6 Хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээний гүйцэтгэлийн хугацааг сунгаж болно.

### Гурав. Төлбөр тооцоо

- 2 Захиалагч нь **Үйлдвэрийн уурын шугам** засварын ажил-ыг (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- 3.2 Гэрээний үнийг тендерт санал болгосон доорх үнийг баримтлан гүйцэтгэнэ.

№	Гүйцэтгэсэн байвал зохих хувь	Нэхэмжлэх мөнгөн дүн /%/	Төлбөр хийгдэх хугацаа	Тайлбар
1	Засварын ажлын 60%-ийг хийж гүйцэтгэсний дараа	50%буюу ..... ₮	Нэхэмжлэлд гарын үсэг зурснаас хойш 15 хоногт 21 хоногт	Гүйцэтгэсэн ажлын хэсэгчилсэн гүйцэтгэл гаргаж талууд гарын үсэг зурсан байна
2	Ажлыг бүрэн дуусгаж, засварын бүх бичиг баримтыг бүрдүүлж, талууд гэрээг дүгнэн актанд гарын үсэг зурж баталгаажуулаад	40%буюу ..... ₮		Засварын ажлын эцсийн гүйцэтгэл баталгаажуулж, засварын акт формуляр холбогдох баримт бичиг 100% бүрдсэн, гэрээг дүгнэн төлбөр тооцооны эцсийн шийдвэр гарсан байна.
3	Баталгаат хугацаа дууссан үед	10%буюу ..... ₮		Талууд протокол үйлдэж баталгаажуулсан байна.

- 3.3 Гүйцэтгэлийн төсвийг “Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжуудыг засварлах хөдөлмөрийн нэгтгэсэн норм ЭХН-8-81-02-2007” номыг үндэслэн төсөв зохиох ба “ДЦС-4” ТӨХК-ний Гүйцэтгэх захирлын 2018 оны 10-р сарын 10-ны өдрийн А/235 тоот тушаалаар тарифыг тооцно.
- 3.4 Гүйцэтгэгч нь гэрээгээр гүйцэтгэх ажлыг бүрэн гүйцэтгэж Захиалагч талд бүрэн хүлээлгэн өгсөн, хүлээн авсан тухай гэрээ дүгнэсэн актанд хоёр талын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсгээ зурж баталгаажуулсны дараа гүйцэтгэгч тал төлбөрийн албан ёсны нэхэмжлэлээ захиалагч талын санхүүд албан ёсоор хүлээлгэн өгсөн өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор нийт гүйцэтгэлийн үнийн дүнгээр санхүүжүүлнэ.

### Дөрөв. Гүйцэтгэгчийн үүрэг

- 4.1 Гэрээт ажлыг гэрээнд заасан хугацаанд чанарын өндөр түвшинд хийж холбогдох шалгалт туршилтыг хийж баримтаар баталгаажуулан захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 4.2 Баталгаат хугацааны дотор гүйцэтгэгчийн ажлын чанараас шалтгаалан гэмтэл гарсан нь актаар батлагдвал үнэ төлбөргүй дахин хийж гүйцэтгэж хохиролыг барагдуулна.
- 4.3 Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч ажиллах ба эдгээр шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд Хяналтын Албаны шаардлагаар засварын ажлыг зогсооно.
- 4.4 Засварын ажил гүйцэтгэхийн өмнө гүйцэтгэгчийн ажиллагчид үйлдвэрлэл, ажлын байрны өвөрмөц онцлог, осол гэмтлээс сэргийлж ажиллахтай холбогдсон урьдчилсан зааварчлагааг ДЦС-4 ТӨХК-н ХА-ны байцаагч инженерүүдээс авч ажилд орно./ Мөн түүнчлэн галын байцаагчаас/

- 4.5 Гүүрэн кран, кранбалка, автокранаар өргөх зөөх ажил гүйцэтгэхдээ эрх бүхий байгууллагад ээлжит шалгалт өгсөн, мэргэжлийн үнэмлэхтэй оосорлогч ,дохиочныг ажиллуулна.
- 4.6 Цахилгааны схем зөөврийн болон байнгын гэрэлтүүлгийг холбох, таслуулах, шилжүүлэх тохиолдолд захиалагчийн шуурхай ажиллагааны хүмүүст захиалга өгч мэргэжлийн хүнээр гүйцэтгүүлнэ.
- 4.7 Гагнуур хийх, галтай ажил гүйцэтгэх үед ажлын байрыг станцын галын постын эрх бүхий хүмүүст үзүүлж зөвшөөрөл авч нарыдаар орно.
- 4.8 Гүйцэтгэгч нь өндөрт ажиллах, суваг шуудуу, худаг дотор ажиллах, битүү саван дотор ажиллах, галтай ажиллах, өргөх зөөх механизмтай ажлуудад аюулгүйн нэмэлт арга хэмжээнүүдийг дүрмийн шаардлагад нийцүүлэн авах үүрэгтэй.
- 4.9 Худаг, суваг, шуудуу, камерт ажил гүйцэтгэхдээ дууссаны дараа тэрчилэн засварлагааны үед заавал таглаж байх. Унаж гэмтэхээс сэргийлж хаалт хашилт тавина.
- 4.10 Засварын дараа бак, шугам хоолойг усаар дүүргэх, усан шахалт туршилт хийхдээ зөвхөн захиалагчийн цех, нэгжийн эрх бүхий хүмүүсийг байлцуулан гүйцэтгэнэ.
- 4.11 Гүйцэтгэгч ажил хийж буй зангилаа нэг бүрийг хэсэгчлэн актаар хүлээлгэж өгөх ба тоноглолын задаргаа хийх бүрд тухайн хэсгийн хяналтын инженерүүдэд үзүүлэн акт бүрдүүлэн тэдний зөвшөөрлөөр хаана.
- 4.12 Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэсний дараа, дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.
- 4.13 Үүнд: а/. Ажлын төсвийн гүйцэтгэл 4 хувь  
 б/. Өөрчлөлтийн буюу угсралтын зураг схем 4хувь  
 в/. Гэрээний хуулбар хувь 4 хувь  
 г/. Гэрээ дүгнэсэн протокол 4 хувь  
 е/. Ашиглалтанд хүлээлгэж өгсөн акт 4 хувь  
 ж/. Материалын тайлан 4 хувь  
 м/. Засварын өмнөх ба дараахь ажлуудыг фото зургаар баримтжуулан хавсаргах 4 хувь  
 н/. Засвараас гарсан хог хаягдлыг зөвшөөрөгдсөн хогийн цэгт хаяж,баримтаар баталгаажуулах 4 хувь
- 4.14 Засварын ажлыг гүйцэтгэх шаардлагатай өргөх зөөх механизмыг гэрээний хугацаанд хэрэглэх тохиолдолд аюулгүй байдлыг ханган засварын хугацаанд өргөх механизмын мастерт захиалга өгч, ажлын төгсгөлд нь дүгнэж байна.
- 4.15 Дотоод тээврийн хэрэгслийг гүйцэтгэгч хариуцна.
- 4.16 Гүйцэтгэгч нь засвараас гарсан хог хаягдлыг тухай бүр нь зайлуулж байхын зэрэгцээ захиалагчийн төлөөлөгч, техникийн удирдлага болон байцаагч нарын тавьсан шаардлагыг бүрэн биелүүлж хариуг бичгээр буюу амаар цаг тухайд нь мэдэгдэж байх үүргийг хүлээнэ.
- 4.17 Гэрээгээр хийгдэх засварын ажилд орохын өмнө уг тоноглолын засварын шугаман графикийг гарган танилцуулж өдөр бүрийн явц, ажлын гүйцэтгэлийг засварын шуурхайд танилцуулж ажлын саатал доголдлыг цаг алдалгүй шийдвэрлүүлж байна.
- 4.18 Засварын ажилд шаардагдах багаж хэрэгслийг гүйцэтгэгч өөрсдөө олж нийлүүлнэ.

- 4.19 Гүйцэтгэгчийн зүгээс гэрээт ажилд шаардагдах сэлбэг хэрэгслэлийн жагсаалтыг гаргаж өгөх үүрэгтэй.
- 4.20 Гүйцэтгэгч тал захиалагч талын зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх үүрэг, хариуцлагыг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
- 4.21 Гүйцэтгэгч нь өөрийн компанийн онцлогийг харуулсан эмблем бүхий, Захиалагч талын ажиллагаадаас ялгарахуйц ажлын хувцастай байна.
- 4.22 Засварын ажлыг гүйцэтгэгч компани нь засварын ажлыг гүйцэтгэх явцад нарядын системийг чанд мөрдөнө.

#### **Тав. Гүйцэтгэгчийн эрх**

- 5.1 Гүйцэтгэгч нь гэрээгээр гүйцэтгэсэн ажил үүргээ гүйцэтгэж дууссаны дараа гүйцэтгэсэн ажлын хэмжээнд тохирсон хөлсөө акт баримт бичгийг бүрдүүлж, баталгаажуулж, албан ёсны нэхэмжлэлийг захиалагчид өгснөөс хойш шаардах эрхтэй.

#### **Зургаа. Захиалагчийн үүрэг**

- 6.1 Гэрээт ажлын шинэчлэл өөрчлөлтийн технологи боловсруулан баталгаажуулж захиалгаар хийгдэх ажилд тусгасны дагуу засварын технологийн мөрдөлтөнд хяналт тавих үүрэгтэй
- 6.2 Хяналтын Албаны шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, эсэргүүцсэн тохиолдолд гэрээг цуцлуулах хүртэл арга хэмжээ авах эрхтэй.
- 6.3 Гэрээт ажлын шинэчлэл өөрчлөлтийн зураг, схем, технологи боловсруулан баталгаажуулж төсөвт тусгасны дагуу засварын технологийн мөрдөлтөнд хяналт тавих үүрэгтэй.
- 6.4 Гэрээт ажилд шаардлагатай сэлбэг материалыг захиалгын хуудсаар, төсөвт тусгагдсаны дагуу хяналтын инженерийн зөвшөөрлөөр Худалдан авах ажиллагааны хэлтэс олгох ба технологийн шаардлага хангасан материал сэлбэгээр хангах үүрэгтэй.
- 6.5 Засварын ажлын явц болон төгсгөлийг ажлын байран дээр нь хянаж тоноглолыг хаах зөвшөөрөл өгөх ба актаар хүлээн авч ашиглалтанд хүлээн авах үүрэг хүлээнэ.
- 6.6 Захиалагч нь суурин өргөх зөөх механизм, шат, токарийн ажил, кислород ба пропанаар гэрээт ажлын хугацаанд тасралтгүй хангах үүрэгтэй.
- 6.7 Захиалагчийн зүгээс гэрээт ажилд шаардагдах сэлбэг хэрэгслэлийн жагсаалтыг төсвийн дагуу гаргаж үндсэн гэрээнд хавсаргах үүрэгтэй.
- 6.8 Гүйцэтгэгчийн ажиллагаад хулгай хийсэн болон хулгайн хэрэгт холбогдсон нь тогтоогдвол захиалагчийг хохиролгүй болгуулах арга хэмжээ авах эрхийг захиалагч эдэлнэ.

#### **Долоо. Захиалагчийн эрх**

- 7.1 Гэрээнд заасны дагуу уг ажлын гүйцэтгэлийг хяналтын инженерүүд тухай бүрнь хянаж баталгаажуулах бөгөөд зураг төсөл, технологи зөрчиж буруу, дутуу, чанаргүй хийсэн ажлыг засуулах, гүйцээж хийхийг шаардах ба уг шаардлагыг биелүүлэх хүртэл санхүүжилтийг зогсоох эрхтэй.
- 7.2 Зураг төсөв, барилгын норм дүрэм, стандартыг зөрчсөн, чанарын гологдол гаргасан, санхүүжилтийг зориулалтын бусаар ашигласан, материал, тээвэр, механизмын зардал, үнийн зөрүүг буруу тооцсон тохиолдолд Захиалагч нь эрх бүхий байгууллага, хүмүүсээр хянуулж

торгууль ноогдуулах ба гарсан хохирол, зардлыг гүйцэтгэгчээр төлүүлэх, шаардлагатай бол байгуулсан гэрээг цуцлах эрхтэй.

7.3 Станцын хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн, эд зүйлийг эвдсэн, хулгайлсан, архи уусан, хэв журмын зөрчил гаргасан гүйцэтгэгч байгууллагыг ажлын байрнаас зайлуулж гэрээг цуцлах эрхтэй.

7.4 Хяналтын Албаны шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, эсэргүүцсэн тохиолдолд гэрээг цуцлуулах хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

#### **Найм. Талуудын хүлээх үүрэг хариуцлага**

8.1 Гүйцэтгэгч тал гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол гэрээнд урьдчилан заасан хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн **0.3%**-ийн алдангийг захиалагч талд төлнө./Үүнд НӨАТ нэмэж тооцно/.

8.2 Захиалагч тал гэрээнд заасан төлөх ёстой төлбөрийг гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн **0.3%**-ийн алданги гүйцэтгэгчид төлнө. Гэхдээ МУ-ын эдийн засгийн хямрал бүхий санхүүгийн эх үүсвэрийн хүндрэлтэй үед алданги төлөхгүй байж болно.

8.3 Баталгаат хугацааны дотор гүйцэтгэсэн ажлын чанар, техникийн гологдол, эвдрэл гарвал захиалагч нь мэдсэн буюу мэдэх боломжит өдрөөс хойш гүйцэтгэгчид мэдэгдэж гүйцэтгэгч нь ажлын 20 хоногийн дотор өөрсдийн хөрөнгөөр засаж хэвийн ажиллагаанд оруулж хүлээлгэн өгөх үүрэгтэй.

8.4 Гүйцэтгэгчийн ажиллагсад хулгай хийсэн болон хулгайн хэрэгт холбогдсон нь тогтоогдвол хулгайлсан эд зүйлийн үнийн дүнг 3 дахин өсгөсөн үнээр захиалагчид торгууль төлөх бөгөөд энэ зөрчил дахин давтагдвал уг гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах эрхийг захиалагч эдэлнэ.

8.5 Торгууль, алданги төлсөн нь үндсэн үүрэг болон учирсан хохирлыг төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

8.6 Захиалагчийн саналаар нэмэгдэл ажил хийгдэх, төсөвт ажилбар, материал, тээвэр, механизмын зардал дутуу тусгагдсан, үнийн зөрүү гарсан тухай бүр хоёр тал харилцан тохиролцож акт протокол байгуулан баталгаажуулж шийдвэрлэнэ.

8.7 4.3-р заалтын шаардлагын дагуу засварын ажлыг зогсоосон хугацаа, түүнээс гарах алдагдлыг гүйцэтгэгч байгууллага өөрөө хариуцна.

8.8 ААД,ТАД, Станцын дотоод журмыг зөрчсөнөөс, түүнчлэн өөрсдийн буруугаас тоног төхөөрөмжийг гэмтээсэн, үйлдвэрлэлийн осол гэмтэл гаргасны улмаас учирсан хохирлыг гүйцэтгэгч байгууллага хариуцна.

#### **Арав. Давагдашгүй хүчин зүйл /Форс мажор/**

10.1.Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг нь энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.

10.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй болсон бол талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээт хугацаан дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу нэг талын санаачлагаар цуцлана.

10.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд Форс мажорын нөхцөлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

#### **Арван нэг. Гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах**

11.1. Энэхүү гэрээнд заасан үүргээ талууд ноцтой зөрчсөн буюу хуульд заасан үндэслэл бий болсон бол талууд хэдийд ч гэрээг цуцлах эрхтэй.

11.2. Хэрвээ талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал урьдчилан тохиролцон хавсралтаар оруулж гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар гэрээний нэг адил хууль зүйн хүчинтэй.

11.3. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болбол захиалагчид урьдчилан бичгээр мэдэгдэж /14 хоногийн өмнө/ харилцан тохиролцож зохих шийдвэр гарсны үндсэн дээр гэрээнд өөрчлөлт оруулах буюу талууд гэрээг дуусгавар болгоно.

#### **Арван хоёр. Бусад зүйл**

12.1. Энэхүү гэрээний үйлчлэл нь талууд гарын үсэг зурж тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, талууд тус тусын үүргээ биелүүлж баталгаат хугацаа дууссанаар дуусгавар болно.

12.2. Талууд энэхүү гэрээг 4 хувь үйлдэж захиалагч 3%, гүйцэтгэгч 1% хувийг хадгалах ба тус бүр нь хууль зүйн адил хүчинтэй.

12.3. Талууд энэхүү гэрээгээр тохиролцсон үйлчлэх хүрээ, цаг хугацаа, нөхцөлийг дур мэдэн өөрчлөх эрх эдлэхгүй.

12.4. Энэхүү гэрээг хэрэгжүүлэх болон хүчин төгөлдөр байх хугацаанд гарч болох бүх маргаан зөрчил зэргийг харилцан тохиролцож шийдэх ба үл тохиролцсон тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагч талыг төлөөлж:

“ДЦС-4” ТӨХК-ИЙН

ТДЗ БӨГӨӨД ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

..... Б.ГАНХУЯГ

/2020 он . . сарын . . /

ЗА-НЫ ДАРГА

..... Ц. АМАРБАЯСГАЛАН

/2020 он . . сарын . . /

ХА-Н ДАРГА

..... Д.ӨСӨХБАЯР

/2020 он . . сарын . . /

ТЭЗХ-ИЙН ДАРГА

..... Ж.ОТГОН

/2020 он . . сарын . . /

СБХ-ИЙН ДАРГА

..... Д.ТӨМӨРТОО

/2020 он . . сарын . . /

ХААХ-Н ДАРГА

..... О.ГАНТӨМӨР

/2020 он . . сарын . . /

ТЦ-ИЙН ДАРГА

..... Ц.БАТМАГНАЙ

/2020 он . . сарын . . /

ХЯНАСАН:

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

..... Ч.БЯМБАСҮРЭН

/20120 он . . сарын . . /

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

..... С.ДОНИД

/2020 он . . сарын . . /

Гүйцэтгэгч талыг төлөөлж:

“.....” ХХК-ИЙН

ЗАХИРАЛ .....

.....

/2020 он . . сарын . . /

## ХОЁР ТАЛЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ:

Захиалагчийн хууль ёсны хаяг:

Монгол улс 16100 Улаанбаатар хот

Баянгол дүүрэг, 20 дугаар хороо

“ДЦС-4” ТӨХК

Утас: 7017-12-84, Факс: 7000-13-74

Гүйцэтгэгчийн хууль ёсны хаяг:

.....**хот**, .....**-р хороо**,

**Утас №**.....

Байгууллагын гэрчилгээ №.....,

**Регистрийн №**.....

Тусгай зөвшөөрөл **№** .....

Данс:.....





